



SBS РАДИО БОЛОН ГАДААД ХЭЛ ДЭЭРХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЦААШДЫН ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХОД ОЛОН НИЙТИЙН САНАЛЫГ АВЧ БАЙНА

SBS өнөөгийн Австралийн хэрэгцээнд нийцүүлэн үргэлж өөрчлөгдөн хөгжиж байхыг эрмэлздэг. Энэ хүрээнд SBS радиогоор хүрдэг гадаад хэл дээрх хөтөлбөрүүддээ тавих гол шалгуур үзүүлэлтүүд дээр олон нийтийн санал зөвлөмжийг авах ажлыг өнөөдрөөс эхлүүлж байна.

Өнөөгийн хурдтай өөрчлөгдөж, улам бүр олон талтай болж буй Австралийн нийгмийг хэрхэн тусгаж байгаагаа магадлах үүднээс гадаад хэл дээрх хөтөлбөрөө үнэлж дүгнэх ажлыг SBS радио хүн амын тооллоготой зэрэгцүүлэн 5 жил тутамд хийдэг.

Хөтөлбөрт тавих шалгуур үзүүлэлтүүдийг 2021 оны хүн амын тооллогын мэдээлэлтэй уялдуулан шинэчилж, ирэх таван жилд ямар хэл дээр хөтөлбөр явуулах, хөтөлбөрөө хэрхэн хүргэх чиглэлүүдээ тодорхойлох болно.

Энэхүү үнэлгээ нь SBS радио, SBS on Demand, подкаст болон бусад дижитал платформуудаар хүрч байгаа SBS-ийн гадаад хэл дээрх хөтөлбөрүүдийг хамрах юм.

Олон нийтийн санал зөвлөмжийг 6 долоо хоногийн турш авч, 11-р сарын 12-нд дуусна. Энд саналаа өгөх нь SBS Radio-ын хөтөлбөр, түүний хамрах хүрээг тодорхойлж, агуулгыг сайжруулахад тухайн нийгмийн бүлгийн дүү хоолой болох бөгөөд ирсэн бүх санал, зөвлөмжүүдийг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдэд тусгах юм.

SBS-ын гадаад хэл дээрх хөтөлбөр, аудио хариуцсан захирал David Hua хэлэхдээ “Олон төрлийн сүвгаар олон хэлээр Австралийн ялгаатай нийгмийн бүлгүүдэд хүрдэг, тэдэнтэй холбогддог нь SBS-ийн онцлог юм. Бид 45 жилийн турш олон нийтэд шинэлэг, утга төгөлдөр үйлчилгээ үзүүлэхийн тулд үйл ажиллагаагаа байнга тохируулан өөрчилж ирсэн. Өнөөдөр бид радио, онлайн, подкастуудууд, апплейкшнээр дамжуулан 60 гаруй хэлээр хөтөлбөрөө хүргэж байна. Энэ үнэлгээгээр бид SBS 50 жилийн ойдоо хүрэхэд ямар өнгө төрхтэй байхыг тодорхойлох юм.

COVID-19 цар тахлын үед цаг үеийн болон эрүүл мэндийн мэдээллийг олон нийтэд тэдний төрөлх хэлээр хүргэж байгаа нь SBS – ын гадаад хэл дээрх хөтөлбөрийн үндсэн ач холбогдлыг харуулж байна. Энэхүү үнэлгээ нь өнөөдөр Австралид оршин суугаа тэдгээр нийгмийн бүлгүүдийн хэрэгцээг хөтөлбөртөө тусгасан хэвээр байх боломжийг олгох гол ач холбогдолтой. Бид ингэж хөтөлбөрөө байнга шинэчлэх нь хэл, соёлын хувьд ялгаатай нийгмийн томоохон бүлгүүд, шинээр бий болж байгаа эсвэл мэдээлэл нэн шаардлагатай байгаа бүлгүүдэд үйлчилгээгээ илүү сайн үзүүлэх боломж олгох юм. Сонсогчдийн хувьд энэхүү үйл ажиллагаанд



санал бодлоо хүргэх нь нэн чухал тул Австралийн өнцөг бүрээс бидэнд саналаа ирүүлэхийг уриалж байна” гэжээ.

Шалгуур үзүүлэлтүүдийг 2022 оны 5 -р сард эцэслэн тогтоох бөгөөд шинэчлэгдсэн хөтөлбөрүүд 2022 оны эцэс гэхэд хүрч эхэлнэ.

Олон нийтийн санал зөвлөмжийг авах ажил 10-р сарын 5-ны өдрөөс эхлэн 11-р сарын 12 хүртэл явагдана. Та шалгуур үзүүлэлтүүдийн төсөлтэй танилцах, өөрийн санал зөвлөмжөө өгөхийн тулд [sbs.com.au/consultation](https://www.sbs.com.au/consultation) хаягаар орно уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах, бидэнтэй холбогдохыг хүсвэл Kate Warnock | kate.warnock@sbs.com.au | 0419 316 135 -д хандаарай.